



2024 оны 4-р сарын 29

Хэвлэлийн мэдээ

АмЧам Монгол “Гүйцэтгэх захирлуудын хэлэлцүүлэг” сэдвээр панел уулзалт зохион байгуулав.



УЛААНБААТАР ХОТ, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2024 оны 4-р сарын 26-ны өдөр “Гүйцэтгэх захирлуудын хэлэлцүүлэг” сэдэвт панел уулзалт, CEO Global Survey 2024 судалгааны тайланг танилцуулах арга хэмжээг гишүүн байгууллага PwC Mongolia-тай хамтран зохион байгуулав.

Энэ удаагийн хурлаар Global CEO Survey 2024 буюу бизнесийн салбарын удирдагч нарын дунд явуулсан судалгааны дүн, тэр дундаа Монголын хувийн хэвшлийн манлайлагчдын судалгааны тайланг дэлгэрэнгүй танилцуулж, сорилт ба боломжуудын талаар санал бодлоо хуваалцав.

Уулзалтад Лхамур брендийн үүсгэн байгуулагч Д. Хулан, MCM Группын Гүйцэтгэх захирал Марк Габел, Прайс-Уотерхаус Күүпер Монголиа (PwC)-ын Улс хариуцсан партнер Шаукат Тапиа, Жи-Мобайл компанийн Гүйцэтгэх захирал Г. Магнай, Хас Банкны Гүйцэтгэх захирал Г. Цэвэгжав нар панелистаар оролцож, АмЧам Монголын ТУЗ-ийн Тэргүүн Гари Биондо хэлэлцүүлгийг удирдан явуулав. Панелистууд Монголд бизнес удирдан авч явах талаар өөрсдийн байр суурь, туршлагаас хуваалцаж, тулгарч буй бэрхшээлүүдийн талаар ярилцав.

Лхамур брендийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал Д. Хулан онцлохдоо “Lhamour-ын зорилго бол гар хийцийн, байгальд ээлтэй арьс арчилгааны бүтээгдэхүүнээр дамжуулан байгаль орчин, хүмүүсийн харилцааг дээдлэх, урамшуулахад оршдог. Бид дэлхийн аль ч улс руу захиалга хүргэх боломжтой шинэ вэбсайтаа саяхан нээсэнг дуулгахад таатай байна. Энэ бол манай компанийн ололт амжилтын томоохон дэвшил юм. Монголын өв уламжлал, орчин үеийн инновацийн аль



алиныг нь түшиглэн Монгол Улс өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадалтай гэдгийг дэлхий нийтэд харуулж байгаад таатай байна” гэлээ.



МСМ Группын гүйцэтгэх захирал Марк Габел хэлэхдээ “MSM Групп нь авъяас чадварыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийж, шинийг санаачилж, автомашин, аж үйлдвэр, хүнсний салбарын хэрэглэгчиддээ зориулан нэмүү өртөг шингэсэн шинэ шийдлүүдийг санал болгож, компани, ажилчид, олон нийт, улс орны урт хугацааны амжилтанд эерэг хувь нэмэр оруулахаар ажилласаар байх болно” гэж онцлов.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн Ази Номхон далайн 29 орны Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.